

Банк санхүүгийн төв байгууллагын үүсэл хөгжил

1921-3-24-энд Монгол улсын хэмжээт цаазат ардын засгийн газар ба Монгол ардын Намын төв хорооны хамтарсан 1-р хурлын тогтоолоор Сангийн бөгөөд эдийн засгийн яамны 2 хэлтэс 7 орон тоотойгоор байгуулсан.

1927 онд Улаанбаатар хотын төсөв орлого 276810.03 зарлага 232183.89 байсан байна.

1928-6-1-энд хуралдсан улсын 11-р бага хуралд сангийн яамнаас тавьсан илтгэлд Улсын 4-р их хурлаас тус улсын төгрөгийг алтан баталгаатай болгох, үнэ ханшийг тогтвортой болгох, гадаадын мөнгийг хэрэглэх явдлыг зогсоох тухай заалтыг биелүүлэх үндсэн дээр :Тус улсын төгрөгийг 1928-4-15-наас алтан ханштай болгосон мөн төгрөгийн хатуу алтан баталгааг, зууны дөчин хувиас доошгүйгээр тогтоож, алтан төгрөгийн хүндийн хэмжээ нь аравтын алтан төгрөгт цэвэр алт нэгэн золотник наяхан цоол-шар ,уул төгрөгийг алтны хүндийн хэмжээг баримтлан явуулах хугацааг 1828-8-1-нээ эхлэн явуулах. Хятадын мөнгөн янчааныг 1828-4-15-нас эхлэн гүйлгэнд хэрэглэхийг зогсоосон гэжээ.

1928-6-1-нд Улсын II-р бага хуралд Улаанбаатар хотын захиргааны хэргийг эрхлэх газраас тавьсан илтгэлд 1928 онд тусгазрын батлагдсан орлого 523537 төгрөг 17 мөнгө зарлагыг 523537 төгрөг 17 мөнгө байжээ.

1930-10-11-нд Засгийн газрын эрхлэх товчооны 65 дугаар тогтоолын 3 дугаар зүйлээр мөнгөн тэмдэгт цаасанд байгаа шашны тэмдэгийг солих, мөн нэгтөгрөгийн зоос хийлгэхээр тогтоосон байна.

1931-2-12-нд мөн эрхлэх товчооны 7 дугаар тогтоолын 6 дугаар зүйлээр шинэ хэвлүүлэх мөнгөн тэмдэгт цаасны загварыг баталсан юм.

1935 онд нийслэл хотын захиргааны зардал төсөв 1165765 төгрөг байсан баүүнээс зөвхөн хот нийгэм хангамжинд 523201 төгрөг буюу 45 хувь, соёл гэгээрлийн зардалд 263262 төгрөг буюу 23.4 хувь, захиргааны аппаратын зардалд 1424183 төгрөг буюу 10.6 хувь гэх мэт ноогдож байжээ.

1944 оноос Үйлдвэр аж ахуйн газруудын хоорондын тооцоонд нэгдсэн журам тогтоож түүнд хяналт тавих үүргийг банканд хариуцуулжээ.

1947-онд батлагдсан цалин хэрэглэлийн тодорхойлолтоос үзэхэд Улаанбаатар хотын хороо, хорины захиргаанд цалин жилээр 241900 хотын захиргааны бүх хэлтсүүдийн жилийн цалин 618900 төгрөг бүгд 860800 төгрөг байна.

1958-7-2-нд Сайд нарын Зөвлөлийн 218 дугаар тогтоолоор Улаанбаатар төмөр замын буудал, мах комбинатад хадгаламжийн касс байгуулахаар заажээ.

1960-3-26-анд Сайд нарын Зөвлөл, Намын Төв Хорооны 125/71 дүгээр тогтоолоор аймаг, хотын гүйцэтгэх захиргаандаа санхүү баримтын шалгалт хийж байх хянах тасгийг 3-4 орон тоотойгоор 1960 оны 2 дугаар хагаст байгуулахаар тогтоожээ.

1963-3-19-энд Сайд нарын Зөвлөлийн 283 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын Толгойтын районд 1963-7-1-нээ банкны хэлтэст байгуулахаар тогтоосон байна.

1964-4-15-анд Сайд нарын Зөвлөлийн 194-р тогтоолоор Улаанбаатар хотын банкны 1964-4-1-нээ эхлэн Улсын банкны ерөнхий хорооноос тусгаарлан байгуулж, тус конторт нийслэлийн тойрогт багтах хадгаламжийн кассуудыг харьяалуулжээ.

1967-8-10-нд Сайд нарын Зөвлөлийн 235-дугаар тогтоолоор Улаанбаатар хотын хадгаламжийн нийт кассыг тооцооны касс болгон өргөтгөхөөр тогтоосон юм.

1974-1-18-энд Сайд нарын Зөвлөлийн 23 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын ажилчны районд 1974 оноос эхлэн банкны салбар хэлтэс байгуулахаар тогтоожээ.